



## ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 12 дугаар сарын 04-ний өдөр

Дугаар 05/14

Улаанбаатар хот

### НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйл, Инновэйшн Инвестмент ХК-ийн Ногдол ашгийн бодлогын 3 дугаар зүйлийн 3.6 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Компанийн 2024 оны эхний хагас жилийн цэвэр ашгаас Компанийн хувьцаа эзэмшигчдэд олгох ногдол ашгийн нэгж хувьцаанд ногдох хэмжээг 20 /хорь/ төгрөгөөр тогтоож, Компанийн 2024 оны эхний хагас жилийн цэвэр ашгийн 70.1 /дал аравны нэг/ хувь буюу 3,697,783,200.00 /гурван тэрбум зургаан зуун ерэн долоон сая долоон зуун наян гурван мянга хоёр зуу/ төгрөгийг Компанийн хувьцаа эзэмшигчдэд мөнгөн хэлбэрээр хуваарилсугай.
2. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гарах бүртгэлийн өдрийг 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрөөр тогтоосугай
3. Ногдол ашгаас хувь хүний болон хуулийн этгээдийн хувьд аж ахуй нэгжийн орлогын албан татвар суутган тооцож, “Үнэт цаасны төлбөр тооцооны төвлөрсөн хадгаламжийн төв” ТӨХХК-аар дамжуулан хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулах замаар ногдол ашгийг 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн дотор хуваарилахаар тогтоосугай.
4. Хувьцаа эзэмшигчдэд ногдол ашгийг хуваарилах ажлыг зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал /Г.Эрдэнэмөнх/-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



А.БАТТАМИР